

**БАТЛАВ.
ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН НЭГТГЭЛ
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРЛЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
М.ЦЭНД**

**“АВТОБУСНЫ КУЗОВ ЗАСВАРТ ТӨМӨР БОЛОН БУСАД МАТЕРИАЛ ХУДАЛДАН
АВАХ” ТЕНДЕР ШАЛГАРУУЛАХАД ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

**Төслийн нэр: “АВТОБУСНЫ КУЗОВ ЗАСВАРТ ТӨМӨР БОЛОН БУСАД
МАТЕРИАЛ ХУДАЛДАН АВАХ”
Төслийн дугаар: НЗТНОНӨААТҮГ/202007062**

**УЛААНБААТАР ХОТ
2020 ОН**

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

[Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ] нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **["Автобусны кузов засварт төмөр болон бусад материал худалдан авах" НЗТНОНӨААТҮГ/202007062]**-ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 09-р сарын 17-ны өдрийн 09 цаг]**-аас өмнө www.tender.gov.mn сайтаар тендерийн материал хүлээж авна.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 09-р сарын 17-ны 09 цаг 10 минут-т өөрийн байрны 207 тоот өрөөнд нээнэ**

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

[Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 3-р хороо, Энгельсийн гудамж, Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын өөрийн байр, 2 давхар, 206 тоот өрөө], Утас-11343169

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | | |
|---|------|---|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. | Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. | Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна. |
| | 2.2. | Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| | 2.3. | Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. | Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. | Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. | Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана. |
| | 5.2. | Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. | Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30хоногийн хугацаанд хүчинтэй байна. |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Тендерт оролцогч нь холбогдох чиглэлээр гадаад дотоод худалдаа эрхлэх үндсэн үйл ажиллагааны чиглэл бүхий хуулийн этгээд байх ба Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар баталгаажуулан ирүүлнэ. /Тухай чиглэлийн бараа материал борлуулж, нийлүүлж ажилладаг дэлгүүр, лангуутай байх/ 2. Ижил төрлийн бараа нийлүүлж ажилласан туршлагатай байх туршлагын мэдээлэл ирүүлэх /ижил төрлийн бараа материал нийлүүлж ажиллаж байсан гэрээ, барааг хүлээлгэн өгсөн комиссын актын хуулбарын хамт ирүүлнэ./ 3. Харилцагч банкны тодорхойлолт /өр зээлтэй эсэх/; 4. Татварын албаны тодорхойлолт; 5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт. 6. Бараа нийлүүлэлтийг хариуцан ажиллах голлох болон туслах ажилтны ажил байдлын тодорхойлолт 7. Бараа нийлүүлэлтийг өөрийн хөрөнгөөр гэрээт хугацаанд нийлүүлж, хүлээлгэн өгөх тухайгаа албан мэдэгдлээр баталгаажуулан ирүүлэх 8. Бараа нийлүүлэлтийн хуваарыг баталгаажуулан ирүүлэх 9. Гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийг хүлээн зөвшөөрч байгаагаа албан бичгээр ирүүлнэ. 10. Шалгарсан тохиолдолд “Техникийн тодорхойлолт”-д тусгасан шаардлагуудыг зөвшөөрч байгаа талаар албан бичиг ирүүлнэ. <p>ТШӨХ-д заасан аль нэг баримт бичгийг дутуу ирүүлсэн буюу ирүүлж буй материал нь тод гаргацтай байх ба засвартай болон харагдах боломжгүй бол ирүүлээгүйд тооцож тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>/Дээрхи тодрхойлолтуудыг тендер зарлагдсанаас хойш холбоглох газруудаас гаргуулж эх хувиар ирүүлнэ.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 3-р хороо, Энгельсийн гудамж, Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын өөрийн байр, 2 давхар, 206 тоот өрөө.</p> <p><i>Захиалагчийг төлөөлж: Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэнд</i></p> <p><i>Утас: 343169</i></p> <p>Огноо: 2020 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр</p> <p>Цаг:09 цаг 00 минут.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 3-р хороо, Энгельсийн гудамж, Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын өөрийн байр.</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 2 давхар, 207 тоот өрөө.</p> <p>Огноо: 2020 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр</p> <p>Цаг: 09 цаг 10 минут</p>

ТӨӨЗ 2.3	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг маягтын дагуу гаргаж ирүүлнэ. -Үнийн саналыг жишиг маягтын дагуу ирүүлэх -Үнийн хуваарийг бүрэн бөглөж ирүүлэх -Нийлүүлэлтийн хуваарийг баталгаажуулж ирүүлэх
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

“Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-т “Кузовын төмөр худалдан авах тухай” Нийлүүлэгдэх бараа бүтээгдэхүүн нь дор дурьдсан техникийн тодорхойлолтод нийцсэн байна.

№	Нэр төрөл	Тодорхойлолт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	
1	Кузовын төмөр	Хар лист төмөр 2мм*1м*2м	Ширхэг	200	
2	Угольник төмөр	5мм	метр	300	
3	Төмрийн таслагчийн ир	Гар таслагчийн ир /жижиг/	Ширхэг	10000	
4	Полсо төмөр	20*30	метр	180	
5	Хөнгөн цагаан булан төмөр	3*3	метр	180	
6	Төмрийн өрөм	5 мм	Ширхэг	100	
		6 мм	Ширхэг	100	
7	Төмрийн шруп 8 толгойтой	5 см	Хайрцаг	40	
		2см	Хайрцаг	40	
		8см	Хайрцаг	40	
8	Төмрийн Зүлгүүр	80 –ын нягттай	метр	500	
9	электрод	2мм 3мм	боодол	100	
10	Зүлгүүрийн машин	Сайн чанарын улсын үйлдвэрийн, хүчин чадал өндөртэй	ширхэг	2	
11		Дрилл			Сайн чанарын улсын үйлдвэрийн, хүчин чадал өндөртэй, эсрэг эргэлттэй
12		Будгийн буу			Сайн чанарын улсын үйлдвэрийн, хүчин чадал өндөртэй

Барааны тодорхойлолт: [Тендерт оролцогчийн санал болгож буй бараа нь техникийн тодорхойлолтод заасантай нийцэж байгааг нотлон харуулах]

Стандарт: Уг бараа нь олон улсын чанарын стандартын шаардлагыг хангасан байна.

Баглаа, боодол: [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодол бүрэн бүтэн, эвдрэл гэмтэлгүй талаар барааг тэмдэглэх]

Бараа хүргэх газар: [Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын агуулах]

Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
					<i>Гэрээ байгуулагдсан өдрөөс</i>	<i>Хуанлийн 21 хоногийн дотор</i>	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[2020.00.00]

(Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ)-ын дарга танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендер торолцогч додил болгохыг үүгээр зөвшөөрч байна.
Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
бусад.				

МАЯГТ

3. ИТГЭМЖЛЭГДСЭН БИЧИГ

Энэхүү тендерийн бичиг баримтад гарын үсэг зурагч _____ компанийн _____ ажилтай _____ овогтой _____ нь _____ компанийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах хууль ёсны итгэмжлэгдсэн төлөөлөгч мөн тул _____ ын дор зурсан гарын үсгийг баталгаажуулж байна.

_____ нь _____ компанийг төлөөлж _____ компанийн нэр дээр гэрээ, хэлцэл байгуулах, ажил эхэлж дуусгах, гүйцэтгэл гаргах, гологдлыг барагдуулах, албан бичиг баримт явуулах зэрэг сонгон шалгаруулалтад холбогдолтой бүх материалд гарын үсэг зурах эрхтэй болно.

Энэхүү итгэмжлэх бичгийг гэрчилж 20__ оны ____ дугаар сарын ____ -ны өдөр гарын үсэг зурав.

Тэмдэг

Байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн

Овог, нэр _____
Гарын үсэг _____

Баталгаажуулагчийн

Овог, нэр _____
Гарын үсэг _____

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
- 1.1. Нийлүүлэх барааны үзүүлэлтийг хангамжийн менежер, засварын инженер шалгаж авна.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага. /Шаардлагагүй/
4. Төлбөр (ГЕН – 7)
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Барааг нийлүүлсэн тоо хэмжээгээр акт үйлдэн хүлээн авсны дараа нийлүүлэгч талын нэхэмжлэхийг үндэслэн захиалагчийн дансанд шилжүүлнэ.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹
- 9.1. Алданги оногдуулах хувь: **[0.5]**
Алдангийн нийт дүн: **[10 хувь]**

¹ Ихэнхтохиолдолд, нэгдолоохоногтоногдуулахалдангигэрээнийүнийн алдангийннийтдүнгэрээнийүнийндүнгийн 10 хувиастустухэтрэхгүй.

0.5 хувиас,

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН НЭТГЭЛ
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Г.ТӨМӨРБААТАР

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

“

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

Улаанбаатар хот

Нэг талаас [**Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ**] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [**нийлүүлэгчийн нэр**] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [**гэрээний нэр, дугаар**]-г (цаашид “бараа” гэх) [**гэрээний үнийг тоогоор болон үсгээр**] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____-наас _____ оны __ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;

² Гэрээбайгуулахүедүүнийгхасна.

³ Хоёрталхарилцантохиролцожгэрээнийнөхцөлдоруулсанзайлшгүйшаардлагатайнэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]